



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа
УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/7/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг:
narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: В.Жавзмаа

Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
3.Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.9. Аудитын илрүүлэлт	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	12
Аудитын зөвлөмж	12
4. Менежментийн захидал	13

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 99
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЭРДЭНЭТ
ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН
АШИГЛАЛТЫН ӨМНӨХ
ЗАХИРГАА УТҮГ-ЫН ДАРГА
М.ЭНХБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Эрдэнэ үйлдвэр ТӨҮГ, Орхон аймгийн хамтын ажиллагааны хүрээнд гэрээ байгуулан тус цэцэрлэгт хүрээлэнг барьж байгуулж байгаа бөгөөд тус гэрээ нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,300.00	2,205,825.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,100.00	10,525.20
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,100.00	10,525.20
3121	Төгрөг	9,100.00	10,525.20
31213	Арилжааны банк дахь харилцах	9,100.00	10,525.20
35	БАРАА МАТЕРИАЛ	156,200.00	2,195,300.00
351	Түүхий эд материал	156,200.00	1,793,200.00
35110	Тусгай зориулалттай материал	156,200.00	1,793,200.00
354	Хангамжийн материал	-	402,100.00
35410	Бичиг хэргийн материал	-	165,100.00
35420	Аж ахуйн материал	-	87,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	150,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,213,711,017.93	3,678,087,572.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,213,711,017.93	3,678,087,572.73
392	Биет хөрөнгө	2,213,711,017.93	3,677,037,572.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,210,646,265.29	3,762,167,043.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,345,603.11)	(154,126,237.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,466,709.00	65,333,161.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,047.58)	(2,843,340.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,990,280.00	7,060,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,585.67)	(553,633.71)
393	Биет бус хөрөнгө	-	1,050,000.00
39301	Програм хангамж	-	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(150,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,213,876,317.93	3,680,293,397.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,213,876,317.93	3,680,293,397.93
51	Засгийн газрын хувь оролцоо	2,213,876,317.93	3,680,293,397.93
512	Хуримтлагдсан үр дүн	2,213,876,317.93	3,680,293,397.93
51210	Өмнөх үеийн үр дүн	2,213,876,317.93	2,213,876,317.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,466,417,080.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,213,876,317.93	3,680,293,397.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,230,979,994.29	1,695,213,757.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,221,562,094.29	1,695,213,757.28
120	Нийтлэг татварын бус орлого	2,216,179,454.29	1,695,213,757.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,216,179,454.29	1,695,213,757.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,216,179,454.29	1,616,957,530.08
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,382,640.00	-
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5,382,640.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,417,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,417,900.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,417,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,721,036.36	228,796,677.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,721,036.36	228,796,677.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,721,036.36	228,301,377.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,293,909.00	57,990,034.00
210101	Үндсэн цалин	8,293,909.00	57,990,034.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	949,119.72	6,814,488.86
210201	Тэтгэврийн даатгал	706,927.08	5,098,885.62
210202	Тэтгэмжийн даатгал	83,167.89	537,468.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	66,534.33	429,974.99
210204	Ажилгүйдлийн даатгал	900.00	52,515.84
210205	Эрүүл мэндийн даатгал	91,590.42	695,643.84
2104	Хангамж, бараа материалын зардал	23,071.28	2,761,050.00
210401	Бичиг хэрэг	23,071.28	589,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,700.00	31,407.92
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62,700.00	31,407.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,392,236.36	155,280,975.28
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,392,236.36	155,280,975.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,219,258,957.93	1,466,417,080.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,219,258,957.93	1,466,417,080.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,417,900.00	78,256,227.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	78,256,227.20
120	Нийтлэг татварын бус орлого	-	78,256,227.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	78,256,227.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,079.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	78,255,148.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,408,800.00	78,254,802.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,408,800.00	78,254,802.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,408,800.00	77,759,502.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,862,966.98	57,990,034.00
210101	Үндсэн цалин	8,862,966.98	57,990,034.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	380,061.74	6,814,488.86
210201	Тэтгэврийн даатгал	287,744.56	5,098,885.62
210202	Тэтгэмжийн даатгал	33,861.30	537,468.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,083.58	429,974.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,041.30	52,515.84
210205	Эрүүл мэндийн даатгал	30,331.00	695,643.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,960,421.22
210301	Гэрэл, цахилгаан	-	4,909,821.22
210303	Цэвэр, бохир ус	-	50,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,071.28	3,122,150.00
210401	Бичиг хэрэг	43,071.28	754,100.00
210402	Тээвэр, шатахуун	-	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	55,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	384,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,329,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,641,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,098,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,542,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,700.00	1,231,407.92
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	122,700.00	31,407.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	495,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	495,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	495,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,100.00	1,425.20
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,100.00	1,425.20
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,100.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,100.00	10,525.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			2,213,876,317.93		2,213,876,317.93
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,213,876,317.93	-	2,213,876,317.93
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	2,213,876,317.93	-	2,213,876,317.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,213,876,317.93	-	2,213,876,317.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			1,466,417,080.00		1,466,417,080.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,680,293,397.93	-	3,680,293,397.93

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга М.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл, хөтлөлт, бараа материалын тооллого болон дотоод хяналт хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ нь 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэсэн статустай байна.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг ногоон байгууламж бий болгох, Эрдэнэтийн иргэдийн чөлөөт цагаа эрүүл, аюулгүй, тохилог орчинд зөв боловсон өнгөрүүлэх орчин бүхий цэцэрлэгт хүрээлэн гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ нь 2020 оны санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын СХАА-аас хяналт шалгалт хийгээгүй байна.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд эрсдэлгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоосон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлого 46,079.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 460.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн суурь үзүүлэлтийг тайлант оны жилийн нийт орлого 78,256.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 782.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,466,417.1 мянган төгрөгөөр буюу 66.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.1	10.5	1.4
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	156.2	2,195.3	2,039.1
Үндсэн хөрөнгө	2,213,711.0	3,678,087.6	1,464,376.6
Нийт хөрөнгийн дүн	2,213,876.3	3,680,293.4	1,466,417.1
Өр төлбөр			
Эздийн өмч	2,213,876.3	3,680,293.4	1,466,417.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,213,876.3	3,680,293.4	1,466,417.1

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10.5 мянган төгрөг болж 1.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,195.3 мянган төгрөг болж 2,039.1 мянган төгрөгөөр өссөн нь хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, багаж сэлбэгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,678,087.6 мянган төгрөг болж 1,464,376.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудаас шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,680,293.4 мянган төгрөг болж 1,466,417.1 мянган төгрөгөөр орон нутгийн өмч нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийн тооцоог аймгийн ЗДТГ, ОНӨГ орон нутгийн өмчийн бусад байгууллагуудын төсөвтэй ижил төстэй байдлаар боловсруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн хуваарь баталж, түүнийг мөрдөж ажилласан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 78,255.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс ашигладаггүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус байгууллага 146 мэдээлэл мэдээлэхээс 137 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 7 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна. Мөн 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7, 9, 12 сарын мөнгөн гүйлгээ болон төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийн 562,181.5 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2		2		100
Нийт дүн	2		2		

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 565,734.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 562,181.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,553.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7, 9, 12 сарын мөнгөн гүйлгээ болон төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийн 562,181.5 мянган төгрөгийн мэдээллийг залруулж мэдээлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа зөрчил үүсээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3,553.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд тус байгууллагыг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжих асуудлыг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аж ахуйн болон бичиг хэргийн материалаас баримт үдэгч, ажлын хувцас, ус буцалгагч зэрэг эд хариуцагчид олгосон материалыг зарцуулснаар тайлагнасан, шатахуун зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй байна. Эдгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байдал, үнэлгээ болон хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл: Үргүй зардал өсөх, мэдээлэл хэрэглэгчийг алдаатай мэдээллээр хангах.

1.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл, хөтлөлтөд НББ-ийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, аргачлалыг мөрдөж, дотоод хяналт хэрэгжүүлэх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 67 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал асуудал

2.1 Илрүүлэлт: Бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо хийж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Хөрөнгө эзэнгүйдэх, дутагдах, алдагдах, үргүй зардал өсөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тооцож байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 67 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны
санхүүгийн тайланд аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ 2020 оны жилийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/7/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.	2,195.3	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Энхбат Я.Ариунаа
2	Аж ахуйн болон бичиг хэргийн материалаас баримт үдэгч, ажлын хувцас, ус буцалгагч зэрэг эд хариуцагчид олгосон материалыг зарцуулснаар тайлагнасан, шатахуун зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй.	1,358.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Энхбат Я.Ариунаа
ДҮН		3,553.3			

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ

